



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.15 № 310
танай _____ ны № _____ т

“ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН
ИРЭЭДҮЙ” ОНӨХХК-ИЙ ЗАХИРАЛ
Б.ОДХҮҮ ТАНАА

Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөсөн.

“Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

Аймгийн аюулгүйн нөөцийн 15,000 боодол өвс, 70 тонн тэжээлийг ОНХС-гийн хөрөнгийн 150.0 сая төгрөгөөр бэлтгэх сонгон шалгаруулалтад тэнцсэн “Өвөлжөөн булаг” ХХК-иар бэлтгүүлж аймгийн ажлын хэсгийн актаар хүлээн авч “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-д өгсөн боловч тайланд орлогодож аваагүй,

Аудитын явцад тулган баталгаажуулалт хийхэд аймгийн аюулгүйн нөөцийн 150.0 сая төгрөгийн 15,000.0 боодол өвс, 70 тн тэжээлийг “Өвөлжөөн булаг” ХХК-аар бэлтгүүлж аймгийн ажлын хэсэг “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-д хүлээлгэж өгснийг тулган баталгаажуулахад 10,493 боодол өвс, 54 тн тэжээлийг худалдан борлуулж үлдэгдэл 27.0 сая төгрөгийн 4,507 боодол өвс, 14.4 сая төгрөгийн 16 тн тэжээлийг дутуу нийлүүлсэн,

Тайлант онд цалинг тооцохдоо нийгмийн даатгалын тахир дутуугийн 70, 22 төрлөөр бодогдох 2 албан хаагчийн цалинг энгийн албан хаагчаар буюу 11.5 болон 10.3 хувиар тооцон 537,664.0 төгрөгийг илүү суутгасан,

Тайлант онд үндсэн хөрөнгийн тооллогоор 2018 оны хөрөнгө оруулалтаар ирсэн баяд үүлдрийн 46.1 сая төгрөгийн 160 толгой хуц, дархад үүлдрийн 36.0 сая төгрөгийн 135 толгой хуц, эрчмийн хар ухна 44.1 сая төгрөгийн 245 толгой хуц, 2021 оны хөрөнгө оруулалтаар ирсэн “Герфорд” үүлдрийн сэлэнгийн 1 дүгээр

000020717

үеийн эрлийз 52.5 сая төгрөгийн 15 толгой бяруун бухыг жилийн эцсийн тооллогын бүртгэлд байгаагаар тоолсон боловч байгаа эсэх нь тодорхойгүй, хуулийн байгууллагад шалгагдаж байгаа,

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 19.8 сая төгрөгийн үнэтэй "Бонго-3" маркийн ачааны автомашин, 13.9 сая төгрөгийн үнэтэй 04кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам нийт 33.7 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-аар баталсан "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгаагүй хөрөнгө бэлтгэсэн,

Тайлант онд орлогын төлөвлөгөөг 3 нэр төрлийн 303.1 сая төгрөгөөр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 203.7 сая төгрөг төвлөрч 121.5 сая төгрөгийн орлого тасарсан,

Тайлант онд захирлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/12 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч 5,850.0 сая төгрөгийн хөрөнгийн нягтлан бодогч хуульд заасан хугацаанд дансны үлдэгдлийг тулгаж баталгаажуулж тооцоо бодоогүй,

Тайлант онд гэрээг "ЭБЦТС" ТӨХК-тай 13.9 сая төгрөгийн 04кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын 2 талт гэрээ байгуулсан боловч гэрээг тамга, тэмдгээр баталгаажуулаагүй, гэрээ байгуулаагүй "Кибержаал" ХХК-ны дансанд мөнгийг шилжүүлсэн,

Тайлант онд нийт 68 бяруу худалдан борлуулснаас 47 бярууны 21.3 сая төгрөгийг төвлөрүүлж үлдэгдэл 21 бярууны 9.4 сая төгрөгийн орлогыг төвлөрөөгүй, авлагаар тусгаагүй,

Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 1,495.8 сая төгрөгийн 10 тракторын багцаас 598.3 сая төгрөгийн 4 тракторын багцыг 4 иргэнтэй гэрээ байгуулж эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон боловч авлагаар бүртгээгүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 14.5, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ